


Бүгд Найрамдах  
Ардчилсан Конго  
Улсаас  
МЭНДЧИЛЖ  
байна!

**Бүгд Найрамдах  
Ардчилсан Конго**  
улс төв Африкт  
оршдог. Энд 80 сая  
орчим хүн амьдардаг.



**Сайн уу,  
биднийг  
Марго, Паоло  
гэдэг.**

**Бид Бүгд  
Найрамдах  
Ардчилсан Конго  
Улсаар айлчилж  
байна.**



Ардчилсан Конго улсын ихэнх хэсэг нь ширэнгэн ойгоор бүрхэгдсэн байдаг. Энэ нь заан, горилл, хирс зэрэг төрөл бүрийн сонирхолтой амьтдын өлгий нутаг юм. Энэ амьтныг окапи гэж нэрлэдэг.



Ардчилсан Конго улс өөрдийн үзэсгэлэнт уламжлалт урлаг, тэр дундаа модон сийлбэр, нэхмэл сагс, баг зэргээрээ алдартай.



Ардчилсан Конгод сүм дээр ихэнх хүн нь францаар ярьдаг. Энэ бол энэ улсын албан ёсны хэл юм. Гэхдээ Ардчилсан Конгод бараг 250 өөр хэлээр ярьдаг.



Манай Сүмийн номлогчид 1986 оноос эхлэн Бүгд Найрамдах Ардчилсан Конго Улсын хүмүүст зааж эхэлсэн. Одоо бараг 60000 хүн Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмд харьяалагддаг.



Энэ жил Бүгд Найрамдах Ардчилсан Конго Улс анхны ариун сүмээ хүлээн авсан! Сүмийн гишүүд эх орондоо ариун сүмтэй болсондоо баяртай байна.

**Бүгд Найрамдах  
Ардчилсан Конго улсаар  
бидэнтэй хамт аялсанд  
баярлалаа. Дараа дахин  
уулзацгаая!**

ЗУРАГ ЧИМЭГЭЛЛИЙГ КАТИ МАКДИЙ



**Ардчилсан Конго улсын бидний зарим найзтай танилцана уу!**



“Нэг ням гараг хаа сайгүй цэргүүд байсан ба эцэг эх маань сүмд явахад хэцүү болох нь дээ гэсэн. Би тэдэнд ядаж ариун ёслолдоо оролцох хэрэгтэй гэж хэлсэн юм. Бид бүгдээрээ итгэлээ харуулж, Их Эзэнд хүндэтгэл үзүүлэхээр сүмдээ очсон.”

**Проди К., 7 настай, Бүгд Найрамдах Ардчилсан Конго Улс, Киншаса**



“Би бусдад туслах дуртай. Нэг өдөр манай ангийн хүүхэд завсарлагаанаар идэх юмгүй байсан тул гунигтай байв. Би түүн дээр очоод, идэхээр авчирсан хоолоосоо хуваалцсан.”

**Сэлиа Цидиби К., 5 настай, Бүгд Найрамдах Ардчилсан Конго Улс, Киншаса**

**Та Бүгд Найрамдах Ардчилсан Конго Улсад амьдардаг уу? Бидэнд захидал бичээрэй! Бид таныг сонсохыг хүсэж байна. H24-р хуудсыг үзнэ үү.**